

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 08 ДУГААР САРЫН 25-НЫ  
ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-2
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл</b>	3-8
	1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25- ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	3-8

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 08 дугаар сарын 25-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 19 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилоптой: Г.Ганболд, Б.Пүрэвдорж;  
Чөлөөтэй: Ж.Батсуурь;  
Эмнэлгийн чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Эрдэнэбат.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлж, Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат тайлбар хийв.

**Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18-ын 5-д заасны дагуу санал хураалт явуулав.**

**Ж.Мөнхбат:** 1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их

Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хүчингүй болсонд тооцсугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 1  
Бүгд: 14  
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 1  
Бүгд: 14  
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА** **Ж.МӨНХБАТ**

Тэмдэглэл хөтөлсөн:  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ** **П.ОЮУНГЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 08 ДУГААР  
САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Мөнхбат:** Ирц бурдсэн байна.

Байнгын хорооны 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хороодын өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүн Ж.Ганбаатар, Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Амарсайхан, Нямбаатар, Тогтохсүрэн, Баатарбилэг, Занданшатар, Оюунчимэг, Нямаагийн Энхболд, Мөнхбат, Бямбацогт, Мөнх-Оргил, Оюун-Эрдэнэ гэсэн ийм гишүүдийн ирцтэйгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаан албан ёсоор эхэлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүн 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дөрвийн нэгийн гуравт горимын санал гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг хэлнэ гэж заасан. Горимын санал гараагүй учраас хэлэлцэх асуудалдаа орьё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлгийг явуулъя. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын жаран хоёр гишүүн 2022 оны 8 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн арван наймын гуравт, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Байнгын хороонд харьялагдах нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн ирцтэй бол түүнийг Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд ирц хүчин төгөлдөр үзнэ гэж заасан байгаа.

Ингээд сая та бүхэндээ ирцийг танилцуулсан.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна. Нямаагийн Энхболд гишүүнийг урьж байна.

**Н.Энхболд:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 оны 8 сарын 15-ны өдрийн их суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд 2019 оны 11 сарын 14-нд баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн нэг дэх хэсгийн Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал

харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэн хүчингүй болгож, эцэслэн шийдвэрлэсэн. Үндсэн хуулийн шийдвэрийн талаар олон нийтийн байр суурь янз бүр байна.

Нөгөө талаар Үндсэн хууль, бусад хуулиар цэцийн эцсийн шийдвэрийн зөв бурууг шүүх хэрэгтэй субъект байхгүй. Энэ нөхцөлд Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн гурав дахь хэсэгт зааснаар цэцийн эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлэх, цаашид ийм маргаантай нөхцөл байдлыг давтуулахгүй байх зохицуулалтыг хийх нь түүний Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлд зааснаар төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль болон холбогдох хуульд заасан журмын дагуу тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрх Монгол Улсын Их Хуралд хадгалагддаг. Үндсэн хуулийн цэцийн 22 оны хоёрдугаар тогтоол эрх зүй, хуулийн хэрэглээний практикт өмнө нь гарч байгаагүй нөхцөл байдал үүсгэсэн. Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг хэлэлцэх өөрчлөлтийн уг эхийг нотлон баталгаажуулах, Үндсэн хуульд кодификаци хийх, албан ёсны эрх болгон хадгалах, хэвлэн нийтлэхэд хуульд зарим зохицуулалт хийх шаардлага гарсан тул дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 22 оны 8 сарын 24-ний чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн баталсан.

Эдгээр хуулиудыг баримтлан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн арван наймдугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн наймдугаар зүйлийн наймын нэгийн нэгд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд миний бие жаран хоёр гишүүний хамтаар Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 8 сарын 25-ны өдөр өргөн мэдүүллээ.

Аливаа улсын Үндсэн хууль нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлж, төрийн байгууллын үндсийг тогтоосон үндэсний эв нэгдлийн гэрээ, улс төр, эрх зүйн тулгуур баримт бичиг байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Хорьдугаар зүйл. Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгалан гэсний хүрээнд Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, парламентын арчиллыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн энэ хуулийн төслийг боловсруулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг ийнхүү эцэслэн баталгаажуулах нь Үндсэн хууль, бусад хуулийг зөвхөн Монгол Улсын Их Хурал баталж байх бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа явдал юм гэж хууль санаачлагч үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн энэ төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ж.Мөнхбат:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн тавин дөрвийн штрих нэгийн хоёрт Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар зохицуулаагүй асуудлыг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасан хууль хэлэлцэх ерөнхий журмыг баримтлан хэлэлцэнэ.

Дөчин долоогийн хоёрт, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсоно.

Дөчин долоогийн гуравт, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болох бөгөөд хэлэлцэх эсэх асуудлаар цөөнх болсон гишүүд нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно гэсэн дэгийн хуулийн зохицуулалттай байгаа.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа.

Би дэгийг танилцуулъя.

Тавин дөрвийн штрих нэгийн гуравт Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний асуулт асуух хугацаа таван минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа нэг минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа таван минутаас илүүгүй, нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа нь нэг минутаас илүүгүй, гишүүн үг хэлэх хугацаа таван минутаас илүүгүй байна гэж дэгээр хуульчилсан байж байгаа. Өчигдөр Улсын Их Хурлын дэгийн хуульд өөрчлөлт оруулж баталсан.

Ингээд Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

**Ц.Мөнх-Оргил:** Би горимын л юм тодруулах гэсэн юм. Бид нар ерөнхийдөө ойлгож байгаа. Тэгэхдээ бас энэ протокол эд нарт оруулаад энэ телевиз үзэж байгаа хүмүүст энэ өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн заасан дэгээр явж байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо өндөр босготой ирцийн өндөр босготой, ирцийг нь батлах саналын өндөр босготой явж байгаа журмын хуулиар явж байгаа гэдгийг бас л одоо тодруулж асуух гэсэн юм. Та сая хэлчихлээ. Баярлалаа.

**Ж.Мөнхбат:** Мөнх-Оргил гишүүний асуултад би бас тодруулаад нэг хэдхэн зүйл тодруулчихъя.

Ер нь Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль болон журмын тухай хуульд өчигдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүгээр бол Төрийн байгуулалтын байнгын хороогоор энэ өөрчлөлтийг хэлэлцэхэд бол Байнгын хорооны арван наймын гурав дээр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй бол нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй ирцтэй бол түүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ гээд ингээд заачихсан. Журмын тухай хуульд, өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийн нэмэлт болон өөрчлөлтийг Үндсэн хуулийн одоо нэмэлт, өөрчлөлтийн журмын тухай хуулиар зохицуулна. Тэгэхээр энэ хуулиар зохицуулагдаж байгаа, давхар Улсын

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдаад явж байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу. Кнопоо дарна. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн үг хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Тэгээд миний нэг гол хэлэх гэсэн санаа бол одоо ер нь энэ давхар дээлтэй байх уу, үгүй юу гэдэг Монгол төрийг одоо сүүлийн хэдэн жил чинь одоо хорин гурав, дөрвөн жил одоо ингээд л нэг асуудлаараа маргалдаад л эргэж буцаад энд одоо хэдүүлээ энэ хуулиа батлаад эцэс төгсгөл тавимаар байгаа юм. Тэгээд бидний энэ оруулж ирж байгаа хуулийн төслийн гол санаа бол 92 онд батлагдсан тэр эрх зүйн орчин руу нь буцааж оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл давхар дээлтэй ч байж болно, дээлгүй ч байж болно. Энэ бол ерөөсөө Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал аа, хязгаар байхгүй, бүгдээрээ ч байж болно, аль нь ч байхгүй байж болно. Хамгийн гол нь ажлаа хийж чадах тэр чадвар харгалзсан Ерөнхий сайдын улс төрийн шийдвэрийг одоо хүлээн зөвшөөрсөн. Ингээд энэ асуудлаа нэг тийш нь болгоход чухал байгаа юм.

Энэ асуудлыг нэг тийшээ болгохын хамт, ер нь энэ Улсын Их Хурал энэ бүрэн эрхийнхээ хугацаанд би өөрийнхөө бодлыг л хэлж байгаа шүү, дарга аа, гишүүний хувьд. Гишүүдийн тооны асуудлыг сонгуулийн тогтолцооны асуудлыг нэг тийш нь болгох хэрэгтэй байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд ч гэсэн хэлээд байна шүү дээ. Хэдийгээр гишүүд одоо Доржханд, Адьшаа, Ганибал нарын иргэдийнхээ иргэнийхээ хувьд өргөн барьсан асуудалд тооны асуудал, тогтолцооны асуудал тусгагдсан боловч энэ хоёр асуудлаар Үндсэн хуулийн цэц бол дүгнэлт гаргаж чадахгүй. Энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Энэ давхар дээлийнх нь асуудлаар бол бид нар дүгнэлт гаргана гээд одоо тогтоолоо баталчихлаа шүү дээ. Тэгэхээр тийм, тэгэхээр энэ асуудлыг бас цэгцэлмээр байгаа юм. Яагаад гэвэл энэ чинь гурвуулаа хамт явж байгаа л асуудал шүү дээ. Тийм ээ. Энэ бүрэн эрхийнхээ хугацаанд энэ асуудлыг цэгцэлж дуусмаар байна. Манай тТрийн байгуулалтын байнгын хороо энэ асуудалд анхаарлаа хандуулаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Ж.Мөнхбат:** Мөнх-Оргил гишүүн үг хэллээ. Тэгэхээр Мөнх-Оргил гишүүний саяын энэ үгэнд дурдагдсан хоёр асуудал байгаа. Нэгдүгээрт 1992 онд Монгол Улсад одоо ардчилсан Үндсэн хуулийг батлахад өнөөдрийн одоо бидний давхар дээл ч гэж яриад байдаг. Ингээд л маргаан болоод байгаа энэ асуудал бол одоо бидний өөрчлөлт оруулж байгаа энэ хувилбараар бол батлагдсан байж байгаа. Тэгэхээр бол одоо өнөөдрийн өөрчлөлт бол энэ 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн үзэл санаанд үндсэндээ бол анхны батлагдсан эх хувилбарт нь нийцэж байгаа гэж бас нийцүүлж байгаа гэж ингэж ойлгож болно.

Хоёрдугаарт, энэ сонгуулийн тогтолцоотой холбоотой асуудлаар Үндсэн хуулийн цэц их суудлаараа шийдвэрээ гаргасан. Улсын баяр наадмын өмнө. Тоотой холбоотой асуудлыг бол саяын энэ цэцийн 02 дүгнэлтийн одоо үндэслэл хэсэг дээр дурдсан байгаа. Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо бас энэ асуудлыг одоо судлах, нягтлах, энэ ажлын хэсгийг байгуулаад ингээд Улсын Их Хурлын тогтоолоор энэ ажлын хэсгийг байгуульяа гэсэн ийм одоо бас чиглэлийг Улсын Их Хурлын даргаас өчигдөр чуулганы нэгдсэн хуралдаан дээр чиглэл

өгсний дагуу хоёр ажлын хэсэг байгуулагдана. Тийм, Их Хурлын тогтоолоор байгуулагдаад явна гэдгийг хэлье.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулья.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн арван наймын тав, нэг дэх хэлэлцүүлгээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг хүчингүй болгох, Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн ийм одоо хуулийн зохицуулалттай байж байгаа.

Ингээд санал хураалт явуулья.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн нэг дэх хэсгийн Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хүчингүй болсонд тооцсугай гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

14 гишүүнээс 13 гишүүн дэмжсэн. Ганбаатар гишүүн “Б” танхимд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан даргалж байгаа учир ингээд 92,9 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дагаж мөрдөх хугацааг ярьж, санал хураалгана.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёрдугаар зүйл. Монгол Улсын би энэ тайлбарыг нь бас уншаад танилцуулчихъя.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн арван наймын долоод.

Санал хураалт явуулья.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёрдугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө гэснийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Тийм батлагдсан өдрөөсөө эхэлж улс орон даяар дагаж мөрдөнө гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Дэмжье гэсэн саналын томьёоллоор.

14 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 92,9 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

Энэ дагаж хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдөх хугацааг бол өчигдөр бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар бид нар батлагдсан өдрөө томилно гээд өөрчлөлт оруулаад хуульчилсан байгаа.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцэх энэ удаагийн асуудал дууссан тул түр, хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

**Дууны бичлэгээс буулгасан:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ